

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 110 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ТҮҮХ

Тус цэцэрлэг нь АДХГЗ-ны 1987 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 236 дугаар тогтоолоор одоогийн СХД-ийн 15-р хорооны нутаг дэвсгэр, Барилгачдын гудамж, Өнөр 1-р хороололд ЗХУ-ын тусламжаар баригдаж ашиглалтанд орсон. Анх нээгдэхдээ 280 хүүхдийн ор хоногтой 12 бүлэгт 6 багш, 4 сувилагч, 1 нярав, 5 тогооч, 2 манаач, 12 асрагч, 1 цагаан хэрэглэлийн угаагчтай ажиллаж байжээ.

Анхны эрхлэгчээр нь Даариймаа, 1988-2004 онуудад М.Хандсүрэн нар томилогдон ажиллаж байжээ.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2004 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 171 тоот захирамжаар Цэгмид овогтой Мөнхжаргал эрхлэгчээр томилогдон ирсэн бөгөөд одоог хүртэл тасралтгүй 10 гаруй жил ажиллаж байна.

Тус цэцэрлэг нь 1988-1989 оны хичээлийн жилд Октябрийн районы байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Нөөц бололцоо” уралдаанд тэргүүлж байсан ба багш Ж.Цогзолмаа, Ж.Мөнхцэцэг нар “Заах арга зүйч” цол тэмдэг, 1990-1991 оны хичээлийн жилд тус хамт олон АДХГЗ-ны “Жуух бичиг” мөнгөн шагналаар, бяцхан хүүхдүүдийн сурч боловсрох аятай нөхцлийг бүрдүүлэх, эрүүл ахуйн дадал хэвшлийг эзэмшүүлэхэд олон бүтээлч ажил зохион байгуулснаар Түүдээхүү ахлагчтай гал тогооны баг хамт олон, Д.Ганхуяг, Д.Долгор сувилагчтай яслийн дунд бүлэг Улаанбаатар хотын тэргүүний ажиллагаатай “Соёлч гал тогоо”, “Соёлч бүлэг”-ээр шалгарч, багш Пунцагдулам Боловсролын яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдаж байв. Багш ажилчдыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэхэд анхаарч сагс, гар бөмбөг, бүжиг, одон бөмбөгийн дугуйлан хичээллүүлснээр багш нарын баяраар зохиогддог сагс, одон бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд түрүүлж, Эрхлэгч М.Хандсүрэн “Багшийн алдар” тэмдгээр шагнагдав.

1991-1992 оны хичээлийн жилд сургалт хүмүүжлийн шинэ хөтөлбөр боловсролын яамны 118, 169, 284-р тогтоолын дагуу хүмүүжил сургалтыг өнөөгийн түвшинд ардын сурган хүмүүжүүлэх уламжлал шинэчлэлийг боловсронгуй болгох багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх шаардлагаар энэ хичээлийн жилээс эхлэн заах аргачийн орон тоог батлуулан багш, ажилчдын саналаар багш Ж.Цогзолмааг дэвшүүлэн ажиллуулж байжээ. АБЯ-наас “Багш нарын ур чадвар”-ын уралдаанд оролцож 3-р байр эзлэн баярын бичиг 2000 төгрөгөөр шагнагдав. Боловсролын яамны шалгалтанд цэцэрлэг хамт олноороо “Онц” дүн авч Боловсролын хэлтсийн “Жуух бичиг”-ээр, Ардын хувьсгалын 70 жилийн медалиар багш Ж.Цогзолмаа, Дэлэгмаа, Мөнхцэцэг, Пунцагдулам, Баасандарь, эрхлэгч М.Хандсүрэн, тогооч Түүдээхүү нар, “Эрдмийн лавай” тэмдгээр Ж.Нарантуяа, Ганхуяг, Д.Баснай, Налжирмаа нар энгэрээ мялаав. Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зарласан урлагийн их наадамд бүжгээр Мөнхцэцэг багштай ахлах бүлгийн Батбаатар алтан медаль, дуугаар Долгор багштай бага бүлгийн Бүрэн жаргал хүрэл медалиар шагнагдсан. Боловсролын яамны тушаалаар тус цэцэрлэг нь 3 ээлжээр 12 цагаар ажиллах болсон.

1992-1993 оны хичээлийн жилд эрхлэгч М.Хандсүрэн “Ардын Гэгээрлийн Тэргүүний ажилтан” тэмдгээр, арга зүйч Ж.Цогзолмаа “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, нярав Баасандарь “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулж байв. Хүүхэлдэй урлагийн их наадамд Украйн ардын үлгэр “Тариан түрүүхэн” үлгэрээр О.Болортуяа, Г.Баярхишиг, Ж.Бүрэнжаргал Бурмаа, Билгүүн нар оролцож шагналт байранд шалгарч телевизээр тоглох эрхийн бичиг шагнуулжээ.

Эцэг эхийн санал хүсэлт дээр тулгуурлан багш Ж.Мөнхцэцэг, Д. Долгор багшийн 2 анги бүлэгт англи хэлний сургалтыг нэмэлтээр хичээллүүлж эцэг эхийн талархлыг хүлээсэн байна.

1993-1994 оны хичээлийн жилд тус цэцэрлэгийн мастер багш Юля ахлагчтай баг СХД, хотын тэмцээнд гар бөмбөгийн төрөлд тэргүүлэн 1-р байр, багш нарын ур чадварын тэмцээнд багш Ж.Мөнхцэцэг 1-р байр эзлэн хотын уралдаанд оролцож байжээ.

1994-1995 оны хичээлийн жилд 42 багш ажилчидтай 260 хүүхэдтэй ажиллалаа. Ажиллах хугацаанд Үлгэрийн баатрууд амилсан нь уралдаанд СХД-т тэргүүн байр, хотод 2 дугаар байр эзлэв. Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд СХД-т 2 дугаар байр, багш нарын ур чадварын уралдаанд дуу хөгжмийн багш Ж.Өнөрцэцэг СХД болон хотод 1 дүгээр байр, улсад тусгай байрт шалгарч байжээ.

1995 оны нийслэлийн “Ажил мэргэжлийн аварга багш”-аар дуу хөгжмийн багш Ж.Өнөрцэцэг, 1997 онд нийслэлийн “Ажил мэргэжлийн аварга багш”-аар багш Д.Долгор, 1999 онд нийслэлийн “Ажил мэргэжлийн аварга багш”-аар багш Ө.Сарантуяа, 2001 онд Улсын тэргүүний багшаар заах арга зүйч Ж.Цогзолмаа, 2003 онд багш Я.Норолхоожав Монгол Улсын Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагдсан байна. Хүүхэд багачууд бүх талаар хөгжиж, хүмүүжих ая тухтай орчныг бий болгож, тэднийг сургаж хүмүүжүүлэх ажилдаа тогтвортой амжилт гарган улсын тэргүүний цэцэрлэгийн төвшингийн шаардлагыг хангасан тул тус цэцэрлэгийн хамт олонг 1996 оны 02 дугаар сарын 03–ны өдөр Шинжлэх Ухаан, Боловсролын яамнаас “Улсын тэргүүний цэцэрлэг” болгон диплом мөнгөн шагналаар шагнаж байсан байна.

2002-2003 оны хичээлийн жилд тус хамт олон сургалтын арга барилаа өөрчлөн “Шавь төвтэй” сургалтын аргуудыг нэвтрүүлэн ажиллаж эхэлжээ. Багш нар бүлгийн хүүхдүүдийг хот, дүүрэг, улсын уралдаанд амжилттай бэлтгэн оролцож байв. Үүнд: Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнд СХД-т 2-р байр, Уран хөдөлгөөнт гимнастик” тэмцээнд СХД, улсад 2 дугаар байр,” Уран жиргээ” улсын наадамд Гүенбаатар СХД-т 1, хотод тусгай байр, эстрадын бяцхан дуулаачдын “Мөнгөн хонх” наадмаас Х.Бархас тэргүүн байр зэрэг амжилт гарган ажиллаж байв. Байгууллага хамт олноороо “Хот тохижилт-2002” өргөмжлөл, 2004 онд “Хэрэглэгчдийн найдвартай түнш” өргөмжлөлийг хүртэв.

Эрхлэгч Ц.Мөнхжаргал нь 2004 онд тус цэцэрлэгийг хүлээн авахад 11 бүлэг, 40 багш, ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд ажиллах хугацаандаа ашиглагдахгүй байсан 1 бүлгийн 2006 онд ашиглалтанд оруулж өнөөгийн байдлаар 12 бүлэгт нийт 480 гаруй хүүхэд, 43 багш, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд 2010 онд ашиглагдахгүй байсан 2 сэрүүн өрөөг ашиглалтанд оруулж “Заах аргын нэгдэл”-ийн иж бүрэн танхим болон “Зан заншлын өргөө” болгон ашиглаж байна. 2003-2004 оны хичээлийн жилд Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэн ЕБС-ийг 11 жилийн тогтоолцоонд шилжүүлэх бэлтгэлийг хангах бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулах зорилт тавин ажилласан бөгөөд. 2004 онд Монголын эмэгтэйчүүдийн холбооны “Хөдөлмөрч хамт олон” өргөмжлөлөөр, 2004 онд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээний СХД-т тэргүүн байр, багш Ө.Сарантуяа байгууллагын “Ажил мэргэжлийн аварга багш”-аар шалгаран өргөмжлөл, тууз, мөнгөн шагналаар, Ур чадварын уралдаанд хөгжмийн багш Л.Отгонтамир дүүрэгт 2-р байр, багш

Ц.Дуламсүрэн 3-р байр,2005 онд “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээнд СХД-ийн аварга цом өргөмжлөл, хотод 3 дугаар байр хүрэл медалиар тус тус шагнагдаж байв. Тус цэцэрлэгийн эрхлэгч Ц.Мөнхжаргал нь багш, ажилчдынхаа нийгмийн болон ахуй амьдралд анхаарал тавьж туслах багш Б.Тунгалаг, Т.Долгорсүрэн нарыг 4 жил, ахмад багш Ө.Сарантуяа, Б.Бямбацэцэг, Ц.Сарантуяа, бүжгийн мэргэжилтэй багш Б.Батцэцэгийг нарыг 2 жил МУБИС-ын харъяа Цэцэрлэгийн багшийн сургуулийн оройн ангид багшийн ажил хийн оройн цагийн сургалтаар суралцуулан бакалаврын дипломтой СӨБ багш, арга зүйч мэргэжилтэй болгон төгсгөв. Мөн үндэсний болон бүсийн сургалтанд хамруулж мэдлэг, мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд анхааран сертификаттай сургалтуудад суралцуулж ажиллах арга барил, эв дүй, ур чадвар олгон чадваржуулан сурч, хөгжихөд анхаарч ажиллалаа. 2007 оноос эхлэн багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга асан Л.Найданд хандан өрх толгойлсон туслах багш З.Нямсүрэн багш, Л.Дуламсүрэн нарт 5 ханатай гэр авч өгч, хамт олноос мөнгөн тусламж үзүүлээ. 2004 онд “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнд нийслэл дүүрэгт тэргүүн байр алтан медаль цом, 2004 онд нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу “Хүүхдийн сургууль, цэцэрлэгийн орчинг **Ногоон төгөл** болгон хувиргах” аяны хүрээнд нийслэлд **тэргүүн байрт** шалгарлаа. Манай цэцэрлэг нь хамран сургах харьяалал 15 хорооны 22,23,40 дүгээр байр, 20 дугаар хорооны 5, одоо 12 бүлэгт 480 гаруй хүүхдэд Сургуулийн өмнөх боловсрол олгохоор 43 багш, ажиллагсадтай ажиллаж байна. Манай хамт олонд Хөдөлмөрийн хүндэт медальт багш Ө.Сарантуяа, Б.Бямбацэцэг, Боловсролын тэргүүний ажилтан эрхлэгч Ц.Мөнхжаргал, тэргүүлэх багш Ц.Байгальмаа, Ц.Дуламсүрэн, Л.Отгонтамир, Д.Баснай, БСШУЯамны “Жуух бичиг”-т арга зүйч Н.Лхагва, багш Д.Уранчимэг, багш Б.Баярмаа, 1999 оны нийслэлийн ажил мэргэжлийн аварга дүүргийн 2004 оны бүтээлч багш Ө.Сарантуяа, Дүүргийн 2006, 2007 оны ажил мэргэжлийн аварга багш Б.Бямбацэцэг, 2008 оны дүүргийн ажил мэргэжлийн аварга багш Д.Уранчимэг, Багшийн алдар медальт багш Б.Баярмаа, Д.Төгсцэцэг, МГҮЭХ-ны тэргүүний ажилтан хүндэт тэмдэгт багш Ц.Мөнхжаргал ,Ц.Сарантуяа, Б.Бямбацэцэг, С.Сувданцэцэг, М.Уранчимэг, Ц.Байгальмаа, Б.Тунгалаг, Б.Оюунчимэг зэрэг тэргүүний ажилтан, багш нар ажиллаж, хөдөлмөрлөж байна. Хүүхдийн чанартай хоол хүнсээр үйлчилдэг ахлах тогооч С.Сувданцэцэг, тогооч Наранцацрал, Б.Оюунчимэг нар, Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан цэвэр тохилог байлгахад эмч Л.Гүнсмаа ахлагчтай эрүүл мэндийн тасгийн туслах багш нар Б.Цээсүрэн, Л.Дуламсүрэн, Л.Одгэрэл, Г.Эрдэнэтуяа, Д.Энхмандах, Д.Цогоо, Ц.Ням, Өсөхбаяр, С.Дэлгэрмаа, З.Болорцэцэг,Нямсүрэн Т.Долгорсүрэн нар хамтран ажиллаж хөдөлмөрлөж байна. Үйлчилгээнд жижүүр В.Цэцэгээ, Д.Одончимэг, харуул хамгаалалтанд манаач Ч.Мягмаржав, Гансүх , А.Алтан-Оргил слесарь Лхагважав нар гар нийлэн хамтран ажиллаж хөдөлмөрлөж байна. Тэргүүлэх зэрэгтэй багш -3, Заах аргач зэрэгтэй 11 багш ажиллаж байна.

Цэцэрлэгийн сүүлийн 5 жилийн амжилтаас дурьдвал:

1996 онд Улсын тэргүүний цэцэрлэг

2001,2007,2008 онуудад Нийслэлийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг “Уран хөдөлгөөнт гимнастик” тэмцээний нийслэлийн хошой аварга

- 2004 онд Монголын эмэгтэйчүүдийн холбооны Хөдөлмөрч хамт олон өргөмжлөл”
- **2006 онд “Санхүүгийн улсын стандартыг хангасан байгууллага “**

- **2007** оны Сонгинохайрхан дүүргийн **“ШИЛДЭГ МЕНЕЖМЕНТТЭЙ БАЙГУУЛЛАГА”** –аар
- **2007** онд “Уран хөдөлгөөнт гимнастик” тэмцээний **нийслэлийн аварга**
- 2007 онд **Хүүхэд-Замын хөдөлгөөний цагаан толгой -2007** тэмцээнд СХД-ийн дэд байр
- 2007 онд багш нарын дунд тэмцээнүүдэд тэргүүн байрыг эзлэн байгууллагаар тэргүүн байр цом
- 2007 онд СХД-ийн ЗДТГ газараас **“Байгалийн өгөөж- амтат хоол”** байгууллагын тогооч нарын ажил мэргэжлийн уралдаанд тэргүүн байр
- 2008 онд **“Уран хөдөлгөөнт гимнастик** дүүргийн 1-р байр, **нийслэлийн хошой аваргаар**
- 2008 онд **“Багшийн алдар”** спортын 5 төрлийн тэмцээнд багаараа 2-р байр
- 2008 онд **“Ногоон хувьсал”** үндэсний хөтөлбөр, Атрын 3-р аяны г хэрэгжүүлэх ажлын хүрээнд төмс,хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлж хүн амын хүнсний хангамжийг дээшлүүлэх ажилд тэргүүн байрт шалгаран СХД-ийн Засаг даргын өргөмжлөл
- 2009 оны **“Уран хөдөлгөөнт гимнастик”** тэмцээний СХД-ийн 1-р байр, нийслэлийн 2-р байрын шагналт
- 2009 онд Сонгинохайрхан дүүргийн биеийн тамирын хороо, ЭМН, сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын ажилчдын дунд зохион байгуулсан зохион **“Биеэ тэтгэн чийрэгжүүлэх хийн дасгал”**-ын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд баг хамт олноор тэргүүн байр шалгарсан.
Нийслэлийн засаг даргын **БАТЛАМЖ** авсан амжилт бүтээлээр дүүрэн тэргүүний хамт олон билээ. Багш нарын дунд зохион байгуулдаг **“Ур чадвар -2009”** нээлттэй хичээлийн **дүүргийн тэргүүн байрыг** хөгжмийн багш **Л.Отгонтамир**, багш Д.Уранчимэг дүүргийн дэд байрын шагнал хүртсэн.
2009 онд СХД-ийн багш нарын баяраар **“Хөгжүүлэгч ухаантан”** цомын эзэн,хөгжмийн багш Л.Отгонтамир.
- 2009 онд **ДҮҮРГИЙН ОНЫ ТЭРГҮҮНИЙ ЦЭЦЭРЛЭГЭЭР** шалгарсан.
- 2009 он багшийн алдар спортын 5 төрөлд багаараа тэргүүлэн алтан медаль өргөмжлөл хүртсэн.
- 2010 онд Нийслэлийн биеийн тамирын” **ШИЛДЭГ ХАМТЛАГА”**-аар шалгарсан. Цэцэрлэгийн хүүхдийн **“Уран хөдөлгөөнт гимнастик -2010** “тэмцээнд СХД-ийн 2-р байр нийслэлд тусгай байр
- Нийслэлийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулсан **“Үлгэрийн баатрууд амилсан нь”** тэмцээнд “Тэрх нуурын дэгдээхэй” үлгэрээр СХД, нийслэлийн тэргүүн байр, Алтан Боролдойн цомын эзэн шилдэгийн шилдэгээр шалгарсан.
- Хөгжмийн багш Л.Отгонтамир СХД-ийн багш нарын **“Ур чадвар-2010”** тэмцээнд тэргүүн байр, нийслэлийн шилдэг багш өргөмжлөлт **“Хаврын баяр -2010”** тэмцээнд бага насны хүүхдийн дундах “Шилдэг хос”-ын эзнээр эзэн хамтлагаар нь тусгай байрын шагналт
- Шагайн наадгай-2010 тэмцээнд СХД-ийн Тэргүүн байр алтан цомын эзэн
/Б.Пүрэвдолгор,Саруул /

2010 оны “Бяцхан тод авъяастан” тэмцээний тэргүүн байрын шагналт Энхзул,дэд байрын шагналт Намуунаа **2010 онд** Цэцэрлэгийн 12 бүлгийн бүх хүүхдүүдэд байгаль экологийн хүмүүжил олгохоор 14ш цэцгийн мандалыг барьж цэцэг

тарьсан. Жилийн дараа жимсээ өгөх , 30ш чацарганы мод 10ш үхрийн нүдний мод тариалж туршлагын талбайтай болгосон. Мандлыг цэцэгжүүлсэн. Хүүхдийн тоглоомын гадна талбайд 40ш тоглоомыг Матрушка, Динозавурууд элсний сав, Таван хошуу мал, “Далайн амьтад” , “Торхтой баавгай”, Баатрууд, Хаан хатад үлгэрийн сэдвээр зохиомжлон тоглоомжуулсан.

2011 оны 01 сард зохион байгуулсан УИХ гишүүн Д.Тэрбишдагвын нэрэмжит багш нарын спортын 5 төрөлт тэмцээнд “Волейбол “, “Сагсан бөмбөг “, “Шатрын тэмцээнд 1-р байрыг тус бүр эзлэн багийн дүнгээр тэргүүн байр эзлэн цом өргөмжлөлөөр шагнагдсан.2011 оны сонгинохайрхан дүүргийн биеийн тамирын “**ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА**”-аар шалгарсан амжилттай байна.

2011 онд “**Эрүүл мэндийн дэмжигч**” байгууллагын 3 дугаар зэрэглэл

2012 оны **Нийслэлийн тэргүүний цэцэрлэг** ” өргөмжлөл, хаяг, мөнгөн шагналаар

2012 онд Нийслэлийн 100 жилийн ойн **Хүрээ соёл**”-д тэргүүн байр

2012 онд “**Ногоон гэрэл-цагаан шугам**” тэмцээнд СХД-т Тэргүүн байр, хотод 4

2013 онд **Эрүүл мэндийг дэмжигч** “ байгууллагын 1 дүгээр зэрэглэл болгон ажиллалаа.2013 онд нийслэлийн багшийн индексээр үнэлгээгээр нийслэлд багш Б.Баярмаа тэргүүлэн эхний 6 байр эзлэн 2,5 сая төгрөгөөр, байгууллагын индексээр тэргүүлсэн амжилт бүтээлээр дүүрэн ажиллаж хөдөлмөрлөж байна.

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

Сонгинохайрхан дүүргийн 110 дугаар цэцэрлэг нь өмнө Төрийн архивт цэцэрлэг, яслийн 182 хөмрөгт хөмрөг үүсгэсэн бөгөөд 1987-1999 оны байнга хадгалах 31 ХН шилжүүлсэн байна. Одоо тус байгууллагын архивт 1987-2013 он хүртэлх байнга, түр, 70 жил хадгалах баримтууд хадгалагдаж байсан.

Тус цэцэрлэгийн арга зүйч, архивын ажилтан Н.Лхагва нь 2013 онд 2000-2013 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийхээр нийслэлийн Архивын газрын ажилтан Н.Цацралтуяагаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1987-2013 оны архивын баримтад 2013 оны 10 дугаар сарын 16-наас 2014 оны 03 дугаар сарын 06-ныг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Баримтын бүрдэл:

Байнга хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Эрхлэгчийн тушаал, хурлын тэмдэглэл, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, ирсэн, явуулсан бичиг, санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцэл, нийгмийн даатгалын тайлан, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна

70 жил хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: цалингийн карт, цалингийн тооцооны хуудас, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, Эрхлэгчийн “Б” тушаал зэрэг баримтуудаас бүрдэж байна.

Түр хадгалагдах баримтын бүрдлийн хувьд: Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдол, бэлэн мөнгөний орлого, зарлага, касс, харилцах, цалингийн баримтууд, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, няравын тайлан, аж ахуйн гэрээ, санхүүгийн улирлын тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл зэрэг баримтуудаас бүрдэж байна.

ЭШТБ-ын ажлын явцад:

1.1987-2013 оны баримтуудыг нягтлан шалгаж, ангилан ялгаж, эрхлэгчийн тушаалыг 2008 оноос үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2. Ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг 2008 оноос хойшихийг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, хэрэг бүрдүүлж авсан.

3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс тухайн жилд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнга салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.

4. 2000-2009 оны касс, харилцахын баримт, хүнс материалын тайлан, хүүхдийн хоолны мөнгөний тооцоо, үндсэн хөрөнгө, эд хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл баримтуудыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 12 хэргийн 43 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

5. Мөн тус цэцэрлэгт хадгалагдаж байсан дүрс бичлэгийг нягтлан шалган тусгай төрлийн бүртгэл үйлдэн 2001-2013 оны 5 CD бүхий дүрс бичлэгийн бүртгэл үйлдэв.

6. Нийслэлийн Архивын ажилтны зааврын дагуу нийслэлийн Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй байнга хадгалах 31 ХН бүхий данстай данс нэгтгэж 182 дугаар хөмрөгийн 2/16 дугаар данс үйлдэв. Мөн дансаа 1987-2009, 2010-2013 оноор 2 хуваан Мөн 1987-2009 он хүртэлх баримтыг нийслэлийн Архивын газарт шилжүүлэх, 2010-2013 оны байгууллагын архивт үлдээхээр шийдвэрлэв

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 1987-2009 оны 144 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2013 оны 44 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах үргэлжлэх данс
- 2004-2013 оны 94 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1987-2013 оны 65 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2001-2013 оны 5 CD бүхий дүрс бичлэгийн бүртгэл,
- 2000-2009 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 12 нэр төрлийн 43 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Сонгинохайрхан дүүргийн 110 дугаар цэцэрлэгийн дэргэдэх ББНШК-ийн 2014 оны 03 дугаар сарын 12-ны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.